

ЭРҮҮГИЙН МӨРДӨГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АЖЛЫН БҮТЭЭМЖ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ НӨХЦӨЛ

Н.Золбоо

ДХИС-ийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч,
цагдаагийн хошууч

Товч агуулга: Энэ нийтлэлд эрүүгийн цагдаагийн албаны нутаг дэвсгэр хариуцан ажилладаг дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчдийн ажлын ачаалалд дүн шинжилгээ хийж, ажлын бодит бүтээмжийг нэмэгдүүлэх боломж нөхцөлийг судлан, цаашид ажлын ачаалал бууруулах, ажлын бүтээмж нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой удирдлага зохион байгуулалтын талаар санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Abstract : Our study aims to examine the workload of criminal detectives working in the criminal police departments of police stations and departments in the district that oversee the criminal police service's territory.

We studied the possibilities of increasing the real productivity of the work, and worked to put forward suggestions about management organization that can be implemented in the future to reduce the workload and increase the productivity of the work.

Түлхүүр үгс: Нутаг дэвсгэр хариуцсан газар, хэлтэс, Эрүүгийн мөрдөгч, ажлын ачаалал, ажлын бүтээмж, Дүн шинжилгээ, авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Keywords: Territorial bureaus and divisions, law enforcement investigators, criminal detectives, work loads, analysis, implementation of action.

Оршил

Сүүлийн жилүүдэд Эрүүгийн цагдаагийн албаны Дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгууд дээр үүрэг гүйцэтгэж ажиллаж байгаа эрүүгийн мөрдөгчдийн ажлын ачаалал хэт их байгаагаас эрүүгийн мөрдөгчид ажлаасаа шантарч ажлаа солих, албанаас хүсэлтээр гарах хандлага илтээр ихсэж байгаа тул ЭЦА-ны анхан шатны нэгжийн нөхцөл байдлыг хууль эрх зүйн орчинтой нь судалж, үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага тулгарч байгаа тул, тэдний ажлын ачаалал

болон ажлын бүтээмж үр дүнгийн бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгоход анхаарах санал дүгнэлтийг боловсруулахад илтгэлийн зорилго оршино.

Нэг. Дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн мөрдөгчийн ажлын ачааллын ерөнхий байдал

Нийслэл хотын дүүргүүд дэх нутаг дэвсгэр хариуцан ажилладаг цагдаагийн газар, хэлтсүүдийн Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нарын ажлын ачаалал, хүн хүчний тооцоог Эрүүгийн цагдаагийн албаны хүний нөөцийн

сантай, бүртгэгдсэн хэргийн тоог цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээн дээр үндэслэн мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачаалалын талаарх дүн шинжилгээг хийлээ.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн батлагдсан Эрүүгийн болон, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхлэхэд тодорхой хүндрэл, бэрхшээл үүсч байв. Тухайлбал, хуулийг практикт нэг мөр хэрэгжүүлэх ойлголт муу, ойлголтын зөрүүгээс болж хуулиа буруу хэрэглэх, гомдол, мэдээлэл шалгах хугацаа нь зарим ажиллагааг бүрэн гүйцэт хийж гүйцэтгэхэд хүрэлцдэггүй байсныг 2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр албаны дарга нарт гомдол мэдээлэл шалгах хугацааг 14 хоног сунгах эрхтэй болж нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Мөн алба хаагчдын мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэргийн тоо өссөнөөс хэрэг тус бүрт хүрч ажиллахад хүндрэлтэй болсон төдийгүй, удирдлагын зүгээс шинэ хэрэгжиж буй хуулийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулах дадлага туршлага байхгүйгээс эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачааллыг бууруулах чиглэлээр мэдлэг, арга барил дутагдаж байна.

Цагдаагийн байгууллагад ирсэн өргөдөл гомдлын холбогдогч этгээд тодорхой, тодорхой бусаас хамаарч эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч алба хаагчдыг томилон шалгуулдаг, ингэхдээ гэмт хэргийн шинжтэй эсэхийг тодорхой шалгаж тогтооход цаг хугацаа,

техник, хэрэгсэл зарцуулсны дараа гэмт хэргийн шинжгүй гэж үзэж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж байгаа байдал нь мөрдөгчийн ачааллыг бий болгох нэг хүчин зүйл болж байна. Одоо ажиллаж байгаа эрүүгийн мөрдөгч (чиглэлийн ахлах, эрүүгийн ахлах мөрдөгчийн тоо ороогүй) 350 орчим алба хаагч ажиллаж байна. Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө нийслэлд нэг эрүүгийн мөрдөгч сард дунджаар 5 хэрэг, орон нутгийн эрүүгийн мөрдөгч сард 2 хэрэг шийдвэрлэж гүйцэтгэх ажлын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулах, бусад арга хэмжээг зохион байгуулж байсан бол 2017 оны 07 дугаар сарын 01-нээс хойш нийслэлд ажиллаж байгаа нэг эрүүгийн мөрдөгч сард дунджаар 8-12 хэрэг, орон нутагт ажиллаж байгаа эрүүгийн мөрдөгч сард 20-30 хэрэг шийдвэрлэж мөн давхар хэрэг бүртгэлтийн 60-180 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа нь эрүүгийн мөрдөгчийн бие даасан, хараат бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжгүй, гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай явуулах цаг завьт хязгаарлаж, ажлын ачааллыг механикаар ихэсгэсэн ба энэ нь мөрдөн шалгах ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлж, гэмт хэрэгтэй тэмцэх болон урьдчилан сэргийлэх үндсэн ажил орхигдож байна¹.

Хоёр. Эрүүгийн мөрдөгчдийн өдөр тутмын хийж гүйцэтгэж байгаа ажлын ачаалалд хийсэн дүн шинжилгээ

Улсын хэмжээнд эрүүгийн мөрдөгч (чиглэлийн ахлах, эрүүгийн ахлах мөрдөгчийн тоо ороогүй) 750-

¹¹ Эрүүгийн цагдаагийн албаны “Хэрэг бүртгэлтийн хэргийн ачааллын талаар” /танилцуулга/ УБ.2018

800 орчим алба хаагч ажиллаж байгаагаас Нийслэлд 350, орон нутагт 444 орчим эрүүгийн мөрдөгч ажиллаж байна.¹ 2015 оны Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө нийслэлд нэг эрүүгийн мөрдөгч сард дунджаар 5 хэрэг, орон нутгийн эрүүгийн мөрдөгч сард 2 хэрэг шийдвэрлэж гүйцэтгэх ажлын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулах, бусад арга хэмжээ зохион байгуулж байсан бол 2017 оны 07 дугаар сарын 01-нээс эхэлснээс хойш нийслэлд ажиллаж байгаа нэг эрүүгийн

мөрдөгч сард дунджаар 7-8 хэрэг, орон нутагт ажиллаж байгаа эрүүгийн мөрдөгч сард 3 хэрэг шийдвэрлэж мөн давхар хэрэг бүртгэлтийн 60-180 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Үүнээс үзвэл, эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачаалал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээс хойш нийслэлд 2-3 нэгжээр буюу 40 орчим хувиар өссөн, орон нутагт 1 нэгжээр буюу 20 орчим хувь өссөн байна².

Зураг 1. 2018 оноос 2023 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ.



Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2 жилийн хугацаанд гэмт

хэргийн тоо өссөн үзүүлэлтэй байсан бол 2020 оноос эхлэн Ковид-19 цар тахалтай холбоотойгоор буурсан байна.

¹ Эрүүгийн цагдаагийн албаны хүний нөөцийн сан

² Эрүүгийн цагдаагийн албаны “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн

ачаалал, хүн хүчний талаар” /танилцуулга/ УБ. 2018

Зураг 2. Нийслэлд ажиллаж байгаа эрүүгийн мөрдөгчийн нэг өдрийн ажлын цаг (ажлын зураглал) ашиглалт.



Хүснэгт 1. Эрүүгийн мөрдөгчийн нэг өдрийн ажлын ачаалалд зураглал.

Ажлын цаг	Хийгдэж байгаа ажил
08 ³⁰ -13 ⁰⁰	Гомдол мэдээлэл хүлээн авч гэрч хохирогчоос мэдүүлэг авах, хойшлуулшгүй ажиллагаа явуулах
13 ⁰⁰ -13 ³⁰	Үдийн цай
13 ³⁰ -17 ³⁰	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, хугацаа сунгах, мэдүүлэг байцаалт авах, бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах, прокурорт хэрэг танилцуулах, прокурорын даалгавар, шаардлагын биелэлтийг хангах, хариу өгөх.
17 ³⁰ -19 ⁰⁰ хамгийн багадаа	Рапортонд сууж хоногийн нөхцөл байдалтай танилцах, удирдлагаас үүрэг чиглэл авах, тасаг албадын хурал ярианд суух
19 ⁰⁰ -22 ⁰⁰ цаг хүртэл	Өргөдөл гомдол, хэрэг бүртгэлтийн хэрэгт хүн хайх, эрэн сурвалжлах, жижүүрийн үүрэг гүйцэтгэх, өөрийн шалгаж байгаа бусад хэрэг бүртгэлтийн хэрэг өргөдөл, гомдолд хийгдвэл зохих бусад ажиллагаа.
Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор	Бусад ажил...

2023 оны 01 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 13-ний өдрийн хооронд дүүрэг дэх цагдаагийн газар хэлтсийн эрүүгийн мөрдөгч нараас авсан судалгааны ажлын санал асуулгыг нэгтгэн дүгнэвэл, судалгаанд оролцогчдын хувьд мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиглэлээр ажлын туршлага бага, ажлын ачаалал хэт их, ачааллыг бууруулах чиглэлээр удирдлагын зүгээс авч хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ нь оновчтой биш,

хүртээмжгүй, алба хаагчдад мэдрэгдэхгүй байна. Алба хаагчид байнга цаг хэтрүүлэн ажилласнаар, албанаас халшрах, сэтгэл гутрал, эрүүл мэнд, зан харилцааны доголдолд орох, өрх гэрийн дунд таагүй харьцаа үүсэх, хувь хүний хөгжилд сөргөөр нөлөөлөх байдал үүсч улмаар ажлаас хүсэлтээрээ гарах, ажлаа хаяж явах алба хаагчдын тоо буурахгүй байгаа нь

харагдаж байна¹.

Цагдаагийн байгууллагаас алба хаагчдын тэр дундаа эрүүгийн мөрдөгчийн ажлын ачааллыг тодорхой түвшинд судлаж, шаардлагатай арга хэмжээ хэрэгжүүлж байгаа боловч эерэг үр дүнд хүрээгүй байдал ажиглагдаж байна. Тухайлбал,

- Нийслэлийн Цагдаагийн газар 2017 онд “Нийслэлийн цагдаагийн газрын харьяа нутаг дэвсгэр хариуцан ажилладаг дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн эрүүгийн мөрдөгч нарын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн”,

- Нийслэлийн Цагдаагийн газар “2012-2018 оны цагдаагийн алба хаагчдын Сэтгэл зүйн судалгаа шинжилгээний тайлан”,

- Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба 2018 оны 10 сарын 18-ны өдөр “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын орон тоо, ажлын ачааллын судалгаа”,

- Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурай удирдлагын алба 2019 оны 01 сарын 07-ны өдөр “Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор авсан зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-ийн талаарх тайлан,

- Эрүүгийн цагдаагийн албанаас “Албаны алба хаагчдаас авсан сэтгэл зүйн тусгай ур чадварын судалгааны дүн-2022 он” зэрэг судалгааны ажлуудыг дурьдаж болох юм.

Алба хаагчид ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд эрх зүйн хамгаалалт хангалтгүй гэж нийт

судалгаанд хамрагдсан алба хаагчдын 57,4 хувь нь илэрхийлсэн бол үүний шалтгааныг ажлын байрны тодорхойлолт нь тодорхой стандартгүй, хэрэг шалгах норм гэж байхгүй, удирдлагаас үйл ажиллагааг чухалчлахаас биш алба хаагчдад анхаарал тавьдаггүй талаар дурьдсан байдаг.

Ажлын цаг ашиглалтын талаар 60-аас дээш цагаар ажилладаг гэж 82,1 хувь нь хариулсан бол зөвхөн 16,1 хувь нь 40-60 хүртэлх цаг ажилладаг хэмээжээ. Ингэж илүү цагаар ажиллаж байгаа шалтгааныг эрүүгийн мөрдөгчийн үндсэн ажил “ГА” явуулах, хэргийн хугацаа тулсан, байцаалтад ирэх хүмүүс өөрсдийн зав чөлөөтэй цагт ирэхээс дуудсан цагт ирэхгүй байх, цаг үеийн шинжтэй нийтийн хэв журмын ажилд томилогдох, 1 хүнд ноогдох ажлын ачаалал хэрээс хэтэрсэн байх зэргээр сэтгэгдлээ илэрхийлсэн.

Албанд ажиллах сэтгэл ханамжийн асуултад алба хаагч бүр өөрийн бодлоо чөлөөтэй илэрхийлсэн хариулыг өгчээ. Алба хаагчид 65,4 хувьтай Сэтгэл ханамжтай байгааг илэрхийлсэн байгаа нь өөрсдийн хийж буй ажилд дур сонирхолтой, идэвх сайтай байдаг хэмээн үзэхээр байна. Харин зарим талаар үйл ажиллагааг илүү үр дүнтэй, сэтгэл ханамжтай болох хүчин зүйл дутагдалтай байдаг талаар алба хаагчид сэтгэгдлээ илэрхийлсэн байдаг. Энэ нь гол шалтгааныг алба хаагчдаас тайлбар асуухад ажлын ачааллыг тэнцвэржүүлэх талаар анхаардаггүй, шаардлагатай техник хэрэгслээр хангадаггүй, ажиллах орчин нөхцөл

¹ Нийслэлийн цагдаагийн газар “Харьяа дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн

эрүүгийн мөрдөгчдийн сэтгэл ханамж” судалгааны ажлын тайлан УБ.2017.

хангалтгүй, орон тоо хүрэлцээгүй зэрэгтэй холбоотойгоор ажлаа сэтгэлээсээ хийх урам зориг мохох, түүнчлэн төр засаг, удирдлагын зүгээс эрх зүйн хамгаалалтад итгэл үнэмшил хангалтгүй байгаагаар холбоотойгоор тайлбарлана.

Шинэчлэн батлагдан хэрэгжих хуулиудын талаар алба хаагчид 2 талтай хандсан байдаг. Нэг хэсэг нь мөрдөн байцаагчийн эрх зүйн байдал дордсон, бие дааж шийдвэр гаргах боломжгүй, прокурорын туслах ажилтан болсон мэтээр хариулж байхад нөгөө хэсэг нь ажлын ачаалал дорвитой багасаж, ажлын үр дүн сайжрахаас гадна гэр бүлтэй болон өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдэх талаар дурьдаж сэтгэгдлээ илэрхийлсэн байдаг¹.

Эцэст нь судалгаанд хамрагдсан алба хаагчдаас цөөнгүй хэсэг нь үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй ханддаг болохыг илтгэсэн хариултыг өгсөн байна. Энэ нь байгууллагын хүрээний гадаад, дотоод харьцаа хандлага хэвийн гэхдээ үйл ажиллагаанд учирч болзошгүй эсхүл нэн шаардлагатай байгаа хүчин зүйлсийг бусад судалгааны арга аргачлалаар бодитой судалж, харьцуулсан дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт хийх, цаашдын үр дүнтэй арга замыг тодорхойлох асуудал бий гэдгийн илэрхийлэл гэж үзэж байна.

Ер нь эрүүгийн мөрдөгч гэлтгүй цагдаагийн алба хаагчид нь тэр дундаа тусгай чиг үүрэг бүхий үйл ажилгаатай ажил үүрэг гүйцэтгэдэг алба хаагчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдах байдал сул байгаа нь энэхүү санал асуулгаар

харагдаж байна. Сүүлийн 3 жилд эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эсэх талаар асуухад хамрагдсан гэж 67.7% нь хариулсан хэдий ч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх тал дээр алба хаагчид маань төдийлөн сайн биш буюу 87.1% нь хэвтэж байгаагүй хэмээн хариулт өгчээ.

Алба хаагч нар тогтвор сууршилтай ажиллахгүй байгаа гол шалтгаан нь алба хаагчийг бодитоор үнэлж, дүгнэхгүй байгаагаар холбоотой. Миний бие хүртэл ажлаас өөрийн хүсэлтээр гарах үгүйгээ бодож байлаа. Цагдаагийн байгууллагын тогтолцоонд мерит зарчмын хэрэгжилт хангалтгүй. Шүүхээс гэм буруутай болохыг тогтоогоогүй байхад хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмын хэрэгжилт сул. Хүний амаар үг хийдэг мөртлөө, цаасан дээр материалжуулагдсан зүйл байхгүй байдаг.

- Хамт олны уур амьсгал

- Орон тоог нэмж ажлын ачааллыг багасгах

- Алба хаагчдыг томилохдоо санал хүсэлтийг нь авч байх

- Ажлын ачаалал, удирдлагын харилцаа

- Өөрсдийн ажилдаа хандах хандлага сул байна

- Алба хаагчдыг тогтвор сууршилтай ажиллах бодлогыг баримтлах хэрэгтэй, мэргэшүүлэх нь чухал байна, нийгмийн асуудалд анхаарах хэрэгтэй, шилжилт хөдөлгөөн хийхэд хүндрэлтэй байдаг гэж // тус тус хариултыг өгчээ.

Дээрх хүчин зүйлсийн зэрэгцээгээр алба хаагчдын ажилдаа чин сэтгэлээсээ хандах хандлага,

¹ Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба “Нутаг дэвсгэр хариуцсан

цагдаагийн байгууллагын орон тоо, ажлын ачааллын судалгаа” УБ. 2018.

эрмэлзэл хангалтгүй байгааг анхааралдаа авах нь цаашид удирдлага зохион байгуулалтын зүгээс авч хэрэгжүүлэх чухал арга хэмжээ хэмээн олонтоо саналаа илэрхийлж, нэрлэсэн байна.

1. Эрүүгийн цагдаагийн албаны Гүйцэтгэх ажлын дүн шинжилгээний хэлтсийн 2018 онд хийсэн алба хаагчдын ажлын ачааллын талаарх тайланд:

Шинээр батлагдсан багц хуулиудтай холбоотой сургалт үр дүн муутай, богино хугацаанд явагдсан, үүнтэй холбоотой прокурор, цагдаа шинэ хуулиудыг хэрхэн ойлгох талаар нэг мөр ойлголтгүй байна. Тухайлбал:

-Дүүргийн хяналтын прокурорууд хуулийг өөр өөрийнхөө тайлбарлаж, гомдол мэдээллийн харъяаллыг өөрчлөн эрүүгийн тасаг руу шилжүүлж байгаа ба эзэн холбогдогч нь тдорхой хэрэгт мөрдөн байцаалтын хэрэг нээхийн оронд нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлтэнд шилжүүлэх шийдвэрийг их гаргаж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна¹.

- Хэрэг үйлдсэн этгээдүүдийг түр саатуулах боломжгүй байгаагаас эрүүгийн мөрдөгч нар батлан даалтанд гадуур шалгах, эсхүл өрөөндөө харж суух зэргээр хүндрэлтэй байдал үүсч, хэрэгтэн оргон зугтах, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл үүсч болзошгүй байна.

- Эрүүгийн мөрдөгч нар жижүүрт гарч ажиллан хоногийн хугацаанд гарсан хэргүүдийг өөртөө авч шалгаж байгаа нь ачаалал үүсгэж

өмнөх гар дээр байсан хэргүүд дээрээ эрэн сурвалжлах болон гүйцэтгэх ажил хийх боломжгүй байна. Иймд жижүүрийн албаны орон тоог нэмэгдүүлэх, эсхүл жижүүрийн эрүүгийн мөрдөгчтэй болох шаардлагатай.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар өргөдөл, гомдол гэмт хэргийн шинж байгаа эсэхийг 5 хоногийн хугацаанд шалгах боломжгүй байна. Тухайлбал: хүн нас барсан хэрэгт шүүхийн шинжилгээний дүгнэлт 14-21 хоног, гэмтлийн зэрэг тогтоох дүгнэлт мөн дээрх хугацаанд гарч байгаа нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хуулийн тохирох зүйл, заалтыг хэрэглэх шийдвэр гаргахад хүндрэл учруулж байна.

Шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоос үүдэлтэй ажлын ачаалал, хүндрэлийг судлах ажил 2017 оноос эхэлсэн. Ийнхүү 2017 оны 11 сарын байдлаар нийт мөрдөн шалгах ажиллагааны ажлын ачааллыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын тасгуудын түвшинд тооцож үзэхэд, эрүүгийн цагдаагийн тасгийн ачаалал 76 хувь, мөрдөн байцаах тасгийн ачаалал 24 хувийг эзэлж байсан².

Дээрх зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын байдлаар нийт мөрдөн шалгах ажиллагааны ачааллыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын тасгуудын түвшинд тооцож үзэхэд, эрүүгийн цагдаагийн тасаг 48.1%, мөрдөн байцаах тасаг

¹ Эрүүгийн цагдаагийн албаны Гүйцэтгэх ажлын дүн шинжилгээний хэлтэс “Хэрэг бүртгэлтийн хэргийн ачааллын талаар” /танилцуулга/ УБ., 2018.

² Нийслэлийн цагдаагийн газар “Харьяа дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн эрүүгийн мөрдөгчдийн сэтгэл ханамж” судалгааны ажлын тайлан УБ., 2017

30.8%, хэрэг бүртгэх тасаг 21.1%-ийн ачааллыг тус тус эзэлж байна.

Цагдаагийн байгууллага дотооддоо гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг шалгах эрх бүхий алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зохион байгуулалт хийхэд хүндрэл үүсгэж байсан гол шалтгаан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Мөрдөгч” гэсэн албан тушаалыг хуульчилсан байхад “Эрүүгийн мөрдөгч” албан тушаалыг бий болгож, эзэнгүй хэргүүдийг мөрдүүлснээр мөрдөн байцаалтын бодит ачааллыг бууруулан, хэрэг бүртгэлтийн /эрүүгийн мөрдөгч/ ачааллыг эрс нэмэгдүүлсэн.

Гурав. Эрүүгийн мөрдөгчийн ажлын бүтээмж нэмэгдүүлэх боломж нөхцөл

Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн зохион байгуулалтын арга хэмжээ нь ажлын ачааллыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч нарын илрүүлсэн хэрэг, шалгасан хэрэг бүртгэлтийн хэрэг, ажилласан ГА-ын арга хэмжээнүүд, зохион байгуулсан ажил арга хэмжээ тасгуудын батлагдсан орон тоотой харьцуулахад алба хаагчид хэт их ачаалалтай болсон гэж үзэхээр байна. Иймд эрүүгийн мөрдөгчийн ажлын байрны тодорхойлтод шинчилэлт оруулах, цагдаагийн байгууллага бүтэц зохион байгуулалтын хүрээнд эрүүгийн мөрдөгчийн үндсэн ажил болох хэрэг илрүүлэх, мэдээ мэдээлэл цуглуулах боломжтой цагийн менежментийг зохицуулах чиглэлээр, эрүүгийн тасгуудыг дотоодод нь хэрэг бүртгэх хэсэг, гүйцэтгэх ажлын хэсэг болгон хуваах, төвийн хэлтсүүд болон,

зарим аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэс хооронд эрүүгийн мөрдөгч нарын орон тоог сэлгэн ажиллуулах зэрэг зохион байгуулалтын нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа цагдаагийн хэлтсүүдийн ажлын ачаалал нь газар зүйн байршил, хүн ам, дэд бүтцийн хөгжлөөс шалтгаалж дүүрэг тус бүрийн эрүү, хэв журмын нөхцөл байдал харилцан адилгүй болсон нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийг 2013 онд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар хэлтэс болгон хороодын хуваарьлалтыг газар, нутгийн байршлаар хийснээс биш эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан хийгээгүй гэж үзэхээр байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсүүдийн эрүү хэв журмын нөхцөл байдалд тохируулан хариуцсан хороодын зохион байгуулалтыг дахин хийх, зарим дүүргүүдийн ачаалал ихтэй хороодод хариуцан ажиллах алба хаагч нэмэлтээр томилож, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

Гэмт хэрэг, зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдын ажлын ачаалал их байгаагаас долоо хоногт 70 хүртэлх цагаар ажиллаж байгаа нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан 40 цаг ажиллахаас даруй 75 хувиар илүү ажиллаж байгаагаас гадна нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын эрүү, мөрдөн, хэрэг бүртгэх тасгийн нэг мөрдөгч 7-10 хоногт нэг удаа жижүүрийн үүрэг гүйцэтгэхэд дунджаар 7 хоногийн 2 өдөрт өөрийн шалгаж байгаа хэрэг,

материалд жигд ажиллагаа хийх боломж хязгаарлагдаж, улмаар хэргийн хугацаа алдах нөхцөл байдал үүсэх болсон.

Дээрх үүссэн нөхцөл байдлаас үзвэл дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн жижүүрийн шуурхай албаны бүрэлдэхүүнд гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийн газарт очиж ажиллах жижүүрийн шуурхай албаны мөрдөгчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн судалгаагаар энэ оны 11 дүгээр сарын байдлаар дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд 2831 орон тоонд 2677, аймгуудын цагдаагийн газар, хэлтсүүдэд 3353 орон тоонд 3146 алба хаагч ажиллаж байна. Мөн нийт бие бүрэлдэхүүний 27.8 хувь нь цагдаагийн үндсэн ажил болох гэмт хэрэгтэй тэмцэх,

нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг гүйцэтгэдэггүй захиргааны ажилтнууд байгаа судалгаа гарсан.

Засгийн газрын 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахын тулд аймгууд дахь цагдаагийн газруудын орон тоог 2508, нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдийн орон тоог 579 орон тоогоор нэмэгдүүлэх, мөн уг тогтоолд тусгагдаагүй боловч шинээр бий болсон ажлын байруудад цаг үеийн шинжтэй ачааллыг тэнцвэржүүлэх бусад хэрэгцээ шаардлагыг харгалзан үзвэл нийт 4443 орон тооны дутагдалтай байгаа судалгаа гарсан тул олон улсын жижиг стандартад нийцүүлэн эрүүгийн мөрдөгчийн орон тоог нэмэгдүүлэх саналаа дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Дүгнэлт

1. Дүүрэг дэх газар, хэлтсийн эрүүгийн мөрдөгчдийн ажлын ачаалал 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотойгоор эрс нэмэгдсэн байна.

2. Эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачаалал нь ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж улмаар ажлаасаа халшрах, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх, албан тушаалаа өөрчлөх талаар хүсэлт гаргах, албанаас халагдах, цаашлаад гэр бүлийн тогтворгүй байдалд хүргэх эрсдэлтэй болохыг судалгаа харуулж байна. Эрүүгийн мөрдөгчийн ажил үүрэг ачаалал хэт их, хариуцлага өндөртэй боловч цалин багатай, завгүй байдал нь албан тушаалаа өөрчлөх нөхцөлийг бүрдүүлж ажлаас хүсэлтээр гарах алба хаагчдын тоо нэмэгдсээр байна.

3. Цагдаагийн байгууллага удирдаж байгаа одоогийн дарга нар Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд одоо байгаа шиг ачааллыг авч ажиллаж байгаагүй учраас эрүүгийн мөрдөгч нарыг хэрхэн ажиллах талаар оновчтой, шалгарсан арга барил хэлж өгөх, зөвлөх, мэргэжлийн удирдлагаар хангах туршлагагүйгээс тогтсон зохион байгуулалтгүй өдийг хүрчээ.

4. Эрүүгийн мөрдөгчийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргийн тоо их байгаагаас хэрэг тус бүрд хэргийн хугацаа сунгах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах тохиолдол бүрд прокурорын зөвшөөрөл авах санал үйлдэж, хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд мэдүүлэг өгөгчийн байгаа газарт

очиж мэдүүлэг авах зэрэг техник ачаалал хэт их байна.

5. Эрүүгийн мөрдөгчийн илүү цагаар ажиллах явдал нь удирдлагын зүгээс байх ёстой хэвийн зүйл мэт хандлага практикт төлөвшсөн байгаа нь цагийн менежмент, зохицуулалт, төлөвлөх чадамж, хяналт суларсныг илтгэж байна. Дэвшин томилогдох боломж нь үндсэндээ хаалттай меррит зарчим үйлчилдэггүй нь албандаа итгэх итгэл алдагдаж ажлын бүтээмж буурч албанаас өөрсдийн хүсэлтээр гарах үндсэн шалтгаан болж байна.

6. Дээрх шалтгаан нөхцөлүүдээс шалтгаалан ажлын дадал туршлага сайтай алба хаагчид ажлаас гарч, ажлаа өөрчлөн явснаас нийт тасгууд орон дутуу, шинэ залуу алба хаагчдыг сурган дадлагажуулах туршлагатай хүний нөөцийн хомсдолд орж мөрдөн шалгах ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг чирэгдүүлэх, залхаах, төрийн байгууллагад итгэх итгэл үнэмшилгүй болох, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх сөрөг үр дагавартай.

Санал

1. Гэмт хэрэг мөрдөн шалгах чиг үүргийн алба хаагчдыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эргүүл, жижүүр, хэв журмын хамгаалалт, хэрэгцээ шаардлагагүй сургалтуудад татан оролцуулахгүй байх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлснээр эрүүгийн мөрдөгчид ирэх ажлын хэт их ачаалал буурах нэг үндэслэл болохыг судалгаа харуулж байна.

2. Эрүүгийн мөрдөгчийн ажлын байрны тодорхойлолтыг

бусад хууль тогтоомжтой нийцүүлэн, нийгмийн баталгаа цалин хангамж дээр анхаарч, ар гэртээ зарцуулах цаг гаргаж өгөх ажлыг зохион байгуулах.

3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хугацаа сунгуулах, прокурорын зөвшөөрөл авах, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцахад албан бичиг боловсруулах, зөвшөөрөл авах зөвшөөрөл зуруулах албан тушаалтныг хүлээх зэрэг маш их хугацаа шаарддаг техник ажиллагаануудыг цахим хэлбэрт шилжүүлэх чиглэлээр УЕП, ЦЕГ-ын хамтарсан журам боловсруулж хэрэгжүүлэх / Энэ талаар ямар нэгэн арга хэмжээ авч байгаагүй/.

4. Дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгуудын бүтэц үйл ажиллагааны зохион байгуулалтыг дахин шинэчлэх / Хэрэг бүртгэх хэсэг, Гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг /.

5. Эрүүгийн цагдаагийн эрүүгийн ахлах албан тушаалтнуудын зөвлөгөөнийг улирал тутамд зохион байгуулах тэднээс гарсан санал хүсэлтийг ЭЦА-ын удирдлага, НЦУГ-ын удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх.

Эх сурвалжийн жагсаалт

-Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл 1992. №1.

-Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга. Төрийн мэдээлэл 2015. №3

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл 2017.№4.

-Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл 2017.02.09. №3

-Нийслэлийн цагдаагийн газар “Харьяа дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн эрүүгийн мөрдөгчдийн

сэтгэл ханамж” судалгааны ажлын тайлан УБ.2018.

-Эрүүгийн цагдаагийн албаны “Хэрэг бүртгэлтийн хэргийн ачааллын талаар” /танилцуулга/ УБ.2018.

-Эрүүгийн цагдаагийн албаны “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн ачаалал, хүн хүчний талаар” /танилцуулга/ УБ. 2018.

-Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын орон тоо, ажлын ачааллын судалгаа” УБ. 2018.

-Эрх зүйн мэдээллийн нэгдсэн портал- www.legalinfo.mn;

-Цагдаагийн Ерөнхий газар- www.police.gov.mn